



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 11

Чойр

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн
шалгалтын салбар комисс томилох тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.4.2, 5.1, 5.2, 5.3, 5.3.1, 5.4, 5.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс мэргэшлийн шалгалт авах ажлыг зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

КОМИССЫН ДАРГА:

Д.СУВД - Аймгийн шүүхийн Тамгын газрын дарга, салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

М.АНХБАЯР - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

ГИШҮҮД:


Ж.ОЮУНБИЛЭГ - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

Д.МАГВАНСҮРЭН - Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

Н.ОДОНТУЯА - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

2. Шалгалтын бүртгэл, сорил, ярилцлагын ажлын хэсгүүдийг зохион байгуулж, мэргэшлийн шалгалт авах бэлтгэл ажлыг хангуулан, төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын үйл ажиллагааг журмын дагуу ил тод, шударга зохион байгуулж, салбар комиссын эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг комисс /Д.Сувд/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 13

Чойр

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн
шалгалтын сорилын ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 5.6, 7.2.3, 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс мэргэшлийн шалгалтын сорилын шалгалт авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

Ж.ОЮУНБИЛЭГ – Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Д.МӨНХЗУЛ – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

ГИШҮҮН:

Д.МАГВАНСҮРЭН – Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

2. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын сорилын шалгалтыг журмын дагуу ил тод, шударга зохион байгуулахыг ажлын хэсэг/Ж.Оюунбилэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХА0115
06



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 14

Чойр

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн
шалгалтын бүртгэлийн ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 5.6, 7.2.3, 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс авах мэргэшлийн шалгалтын бүртгэлийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

М.АНХБАЯР – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Д.МӨНХЗУЛ – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.БАТТӨР – Тагнуулын тасгийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

ГИШҮҮД:

Н.ОДОНТУЯА – Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

Ц.ОТГОНЧИМЭГ – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд орох иргэдийг ажлын байранд тавигдах шаардлагыг хангуулан, журмын дагуу бүртгэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг /М.Анхбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХА0115
06



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 15

Чойр

Салбар зөвлөлийн 2017 оны
үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам” – ын 2.2.8, 3.1.2, 3.2.2, 3.2.3, 4.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлийн 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутам тооцон салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХА0115
06



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 16

Чойр

Төрийн албаны мэргэшлийн шалгалтын
салбар комисс томилох тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.4.2, 5.1, 5.2, 5.3, 5.3.1, 5.4, 5.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс мэргэшлийн шалгалт авах ажлыг зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

КОМИССЫН ДАРГА:

Б.БАТТӨР – Аймгийн Тагнуулын тасгийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

М.АНХБАЯР – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

ГИШҮҮД:

Д.МАГВАНСҮРЭН – Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

Н.ОДОНТУЯА – Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

С.УРАНЦЭЦЭГ – Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, салбар зөвлөлийн гишүүн

Г.ТӨРБОЛД – Аймгийн Засаг даргын хэвлэл мэдээллийн ажилтан

Д.МӨНХЗУЛ – Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.ОТГОНЧИМЭГ – Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
А.МЯГМАРЖАМЦ – Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

2. Шалгалтын бүртгэл, сорил, ярилцлагын ажлын хэсгүүдийг зохион байгуулж, мэргэшлийн шалгалт авах бэлтгэл ажлыг хангуулан, төрийн албаны мэргэшлийн шалгалтын үйл ажиллагааг журмын дагуу ил тод, шударга зохион байгуулж, салбар комиссын эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг комисс /Б.Баттөр/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 11, 12, 13, 14 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 14

Чойр

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэнийг нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар хуралдааны Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүнг хэлэлцсэн шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймагт зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн хавсралтад заагдсан нэр бүхий 31 иргэнийг Дэс түшмэлийн ангиллын, 6 иргэнийг Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх, хамгийн өндөр оноо авсан иргэдийг шалгалт өгч тэнцсэн тухайн албан тушаалд томилуулахаар нэрийг нь дэвшүүлэхийг санал болгосугай.

2. Холбогдох шийдвэр, шалгалтын дүн, мэдээг журамд заасан хугацаанд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын Төв комисст хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /М.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 1

Чойр

**Төрийн захиргааны албан хаагчийн тангараг
өргүүлэх санал батлах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.12, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн, төрийн албанд ажиллаж байх хугацаандаа цаашид үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн тасгийн улсын бүртгэгч Төмөрбаатарын Цэвэлмааг Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албан хаагч болгох саналыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /М.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 19

Чойр

Б.Энхцэцэгийг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хүсэлтийг үндэслэн, 2015 онд зохион байгуулагдсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 166 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэгдсэн иргэн Батжаргалын Энхцэцэгийг нэрийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлал хариуцсан мэргэжилтнээр дэвшүүлсүгэй.

2. Иргэн Б.Энхцэцэгийг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Гансүх/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 18

Чойр

「 О.Долгорыг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай 」

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.2.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. 2015 онд зохион байгуулагдсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэгдсэн иргэн Отгоншагдарын Долгорын нэрийг Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнээр дэвшүүлсүгэй.

2. Иргэн О.Долгорын нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Хатантөмөр/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 20

Чойр

Г.Насанжаргалыг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хүсэлтийг үндэслэн, 2017 онд зохион байгуулагдсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэгдсэн иргэн Ганболдын Насанжаргалын нэрийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хүнс, тэжээлийн дэмжлэг, туслалцаа, нэг цэгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтнээр дэвшүүлсүгэй.

2. Иргэн Г.Насанжаргалыг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Гансүх/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 21

Чойр

Комисс томилох тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 128 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.3, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 8.2, 9, 10 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянтал сумын 1 дүгээр багийн иргэн Ч.Энхцэцэг, Д.Эрдэнэцэцэг нараас тус тус гаргасан гомдлыг хянан шалгаж, дүгнэлт гаргах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

КОМИССЫН ДАРГА

Д.СУВД–Төрийн албаны зөвлөлийн
салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.АНХБАЯР–Төрийн албаны
зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн
бичгийн дарга

ГИШҮҮН:

Д.МАГВАНСҮРЭН–Төрийн албаны
зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

2. Өргөдөл, гомдлыг нягтлан шалгаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комисс /Д.Сувд/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХА0115
06



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 01 өдөр

Дугаар дс

Чойр

Төрийн албаны мэргэшлийн
шалгалтын салбар комисс томилох тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.4.2, 5.1, 5.2, 5.3, 5.3.2, 5.4, 5.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс мэргэшлийн шалгалт авах ажлыг зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

КОМИССЫН ДАРГА

Б.ГАНБАЯР– Мэргэжлийн хяналтын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн
М.АНХБАЯР–Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ГИШҮҮД:

Д.СУВД- Аймгийн шүүхийн Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн
Б.САРАНТУЯА- Аймгийн ерөнхий аудитор, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн
Б.БАТСАЙХАН-Цагдаагийн хэтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн
Д.МӨНХЗУЛ-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.ТӨРБОЛД- Аймгийн Засаг даргын
Тамгын газрын хэвлэл мэдээллийн
ажилтан

Ц.ОТГОНЧИМЭГ- Аймгийн Засаг
даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн

А.МЯГМАРЖАМЦ - Аймгийн Засаг
даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн

2. Шалгалтын бүртгэл, сорил, ярилцлагын ажлын хэсгүүдийг зохион байгуулж, мэргэшлийн шалгалт авах бэлтгэл ажлыг хангуулан, төрийн албаны мэргэшлийн шалгалтын үйл ажиллагааг журмын дагуу ил тод, шударга зохион байгуулж, салбар комиссын эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг комисс /Б.Ганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 24

Чойр

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэнийг нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 10–ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймагт зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн хавсралтад заагдсан нэр бүхий 3 иргэнийг Дэс түшмэлийн зэрэглэлийн, 13 иргэнийг Туслах түшмэлийн зэрэглэлийн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх, хамгийн өндөр оноо авсан иргэдийг шалгалт өгч тэнцсэн тухайн албан тушаалд томилуулахаар нэрийг нь дэвшүүлэхийг санал болгосугай.

2. Холбогдох шийдвэр, шалгалтын дүн, мэдээг журамд заасан хугацаанд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын Төв комисст хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /М.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

